

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-03-19

Өндөртолгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 03 дугаар сарын 25-ны “Мягмар” гарат** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.

8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Эдийн засаг, санхүүгийн нөхцөл хүндрэлтэй байгаатай холбогдуулан дараах арга хэмжээ авах. Үүнд: - Бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх. - Гадаад томилолтуудыг зогсоох. - Нийгмийн баталгаа, хөтөлбөр төслүүдийг түр зогсоох. - Машин, техник, тоног төхөөрөмжийг худалдан авахгүй байх. - Зарим хөрөнгө оруулалт. - Бусад	ЗДТГ, Нийт байгууллагууд
2	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээг эрчимжүүлж, танилцуулах.	СТСХ, ХААА
3	Багахангай, Багануур, Налайх дүүргүүд цаашид газар олголтын асуудлаар санал, дүгнэлт танилцуулах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, ГЗБА
4	Нийслэлийн өмчийн менежментийг боловсронгуй болгох, нийслэлийн өмчид бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй байгаа барилга байгууламжуудыг цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж танилцуулах.	ЗДТГ, Нийт байгууллагууд
5	Нийслэлийн хэмжээнд гэмт, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг	Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг

	сахиулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллах.	
6	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд барилгажилтын өндрийн асуудлаар Монголын архитекторуудын эвлэлтэй уулзах, уулзалт зохион байгуулахтай холбогдуулан холбогдох мэдээллийг авч ажиллах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц
7	Нохой, муур устгах ажлаа эрчимжүүлж, үр дүн гаргаж ажиллах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Хороод
8	Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам, үйчилгээний стандарт болон Зөвшөөрлийн тухай хуулийн талаарх мэдээлэл, сургалтыг зохион байгуулах.	ТХҮХ
9	2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлуудыг эрчимжүүлж ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс
10	Барилга угсралтын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, барилгын норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулж, барилга угсралтын ажлын орчин тойрны өнгө үзэмжийг сэргээх ажлыг эрчимжүүлж ажиллах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд
11	Нийслэлийн хэмжээнд Шар усны үер болон хөрсний усны халиа үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлаа эрчимжүүлж, үерийн хамгаалалтын далан сувгийн лаг шаврыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах.	ОБХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
12	Үерийн эрсдэлтэй бүсэд байгаа айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах.	ОБХ, ГЗБА
13	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040 болон нийслэлд хэрэгжүүлэх 24 мега төслийн талаар НЗДТГ, нутгийн захиргааны болон бусад байгууллагын албан хаагчдад танилцуулах, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах.	ЗДТГ, Нийт байгууллагууд
14	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, цахим хуудас мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.	ЗДТГ, Нийт байгууллагууд
15	Үйлдвэрлэл, технологийн паркуудад тулгамдаж буй асуудлын талаар дараагийн Шуурхай зөвлөгөөн дээр танилцуулах чиглэл өгөгдсөний дагуу холбогдох мэдээллийг бэлтгэн оролцох.	БҮТП ХК
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
16	НҮБ-ын Хүүхдийн сан (Unicef)-гийн санхүүжилтээр баригдсан нийтийн ариун цэврийн байгууламжийн засвар үйлчилгээ, гадна болон дотор орчны тохижилтын ажлыг дуусган үйлчилгээг эхлүүлэх, иргэдэд мэдээлэл хүргэх.	Илч-Орд ОНӨААТҮГ
17	Хүүхдийн чуулганаас гарсан саналуудыг хэрэгжүүлэн ажиллаж, видео хэлбэрээр бэлтгэн мэдээллийг олон нийтэд хүргэх.	Нийт байгууллагууд
18	2 дугаар хорооны клубын засварын ажлыг	Холбогдох албан тушаалтнууд

	эрчимжүүлж ажиллах.	болон гүйцэтгэгчид
19	Улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг иргэд олон нийтэд тогтмол мэдээлж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах.	ЭМТ, Нийт байгууллагууд
20	2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгуулагдах дүүргийн оюутан залуустай уулзах уулзалтын бэлтгэлийг сайтар хангах.	ЗДТГ
21	2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн зохион байгуулагдах Фокус бүлгийн уулзалтуудын хуваарь, цагийн хуваарийг батлан байгууллагын дарга нарт хүргүүлэх.	ЗДТГ, Холбогдох байгууллагын удирдлагууд
22	2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Улаанбаатар хотын Баянгол дүүргийн Оюуны ундраа цогцолбор сургуулиас санаачлан зохион байгуулж буй Тусгаар тогтнол шүлгийг унших, хүүхэд багачуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилготой арга хэмжээг дүүргийн төв талбайд зохион байгуулах тул бэлтгэлийг сайтар ханган ажиллах.	ЗДТГ, Цагдаагийн хэлтэс, НЭБ-ын 91, 94 дүгээр сургууль
23	Өндөрлөг орчимд Түр хоолны газар бий болгох боломжтой байршлуудын судалгааг гарган танилцуулах.	ТХҮХ
24	2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс “Багахангай лиг-2025” волейбол, сагсан бөмбөгийн тэмцээн эхлэх тул санал санаачлагатай оролцох.	Нийт байгууллагууд

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГА

А.СҮХБОЛД

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДБАЯР